

Чойжин ламын сүм музей

2026 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл- ийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.1	“Өндөр гэгээний сүм” (Б.42.5)-ийн сэргээн засварлалтын ажлын зураг, төсөв, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллах	Хандив 535,0	Батлагдсан төлөвлөгөө Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 100	Өндөр гэгээний сүм (Б.42.5)-ийг сэргээн засварлах төсөл 2026 оны 05 дугаар сарын 18- ны өдөр нээлтээ хийж, ажлын төлөвлөлт, хуваарийн дагуу ажлууд хийгдэж байна. Монголын Урлагийн зөвлөл Дэлхийн хөшөө дурсгалын сангийн 90,000 ам. долларын дэмжлэгээр хэрэгжүүлж буй төслийн суурь судалгааны ажил 2025 онд хийгдэж, сэргээн засварлалтын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулан “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ- аар магадлал хийлгэн батлуулсан. Төслийн гүйцэтгэгчээр сэргээн засварлах эрх бүхий “Эм Би Артек Констракшн” ХХК сонгогдон ажиллаж, сэргээн засварлалтын ажил 30 хувьтай үргэлжилж байна. Хүрсэн түвшин: “Өндөр Гэгээний сүм”-ийн сэргээн засварлалтын ажлын зураг төсөл, төсөв батлагдаж, сэргээн засварлах эрх бүхий “Эм Би Артек Констракшн” ХХК сэргээн засварлалтыг ажлыг гүйцэтгэж, төслийн явц 30 хувьтай	100%

						хэрэгжиж байна.	
						Хавсралт: 4 файл	
1.1.2	Музейн сан хөмрөг, үзэсгэлэнгийн танхимын шинэ барилгын концептийн уралдаан зарлаж, дүгнэх	Улсын төсөв 40,0	Уралдааны тоо Шалгарсан бүтээлийн тоо	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	Монголын Архитекторуудын Эвлэл (МАЭ)-тэй “Санамж бичиг”-ийн хүрээнд хамтран ажиллаж, шинэ барилгын концептийн уралдааныг удирдамж, ажлын даалгавар болон холбогдох баримт бичгийн боловсруулалтыг хийж гүйцэтгэлээ. Уралдааны зохион байгуулалтын баг, шүүгчдийн бүрэлдэхүүн, санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлүүлсэн. Ажлын хэсгийн хуралдааныг 5 удаа зохион байгуулж, харилцан санал дэвшүүлж, шийдвэрлэснээр уралдааныг удирдамжийг баталж, 2026 оны 06 дугар сарын 15-ны өдрөөр олон нийтэд нээлттэй зарласан. Хүрсэн түвшин: Монголын Архитекторуудын Эвлэлтэй хамтран уралдааны удирдамж, ажлын даалгавар, холбогдох баримт бичгийн боловсруулалтыг гүйцэтгэн уралдааныг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөр олон нийтэд албан ёсоор зарласан. Хавсралт: 3 файл	100%
1.1.3	“Музейн харуул хамгаалалтын үйлчилгээ авах” тендер зарлаж, түүх, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах	Улсын төсөв 64,8	Гэрээний тоо	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: -	“Музейн харуул хамгаалалтын үйлчилгээ” худалдан авах тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, Музейн захирлын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/120 дугаар бүхий “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар томилогдсон үнэлгээний хороо зохион байгуулж ажилласан. “Музейн харуул хамгаалалт”-ын тендерийг худалдан авах ажиллагааны журмын харьцуулалтын аргаар хялбаршуулсан цахим системээр 2026 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн зарлаж, 1 дүгээр сарын 23-ны	100%

						өдөр нээж, тендерт шалгарсан "Шүтээн уул" ХХК-тай "Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх" ЧЛСМ/20260203001, Х/Г-02 дугаартай гэрээг байгуулан түүх, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Хүрсэн түвшин: Харуул хамгаалалтын үйлчилгээний тендер шалгаруулалтаар сонгогдсон "Шүтээн уул" ХХК-тай "Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх" гэрээг байгуулан түүх, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Хавсралт: 2 файл	
1.1.4	“Занхан сүм”-д хадгалагдаж буй үзмэр эд, өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтын байдлыг үе шаттай сайжруулах	Байгуулагын төсөв 10,0	Гүйцэтгэлийн хувь	-	Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 100	“Занхан сүм”-д хадгалагдаж буй үзмэр эд, өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулах, Доржшүгдэн үзмэрийн гүнгэрвааны суурийн мөөг ургаж, өмхөрсөн хэсгийг засварлаж бэхжүүлэх зорилгоор сэргээн засварлах эрх бүхий "Зэндмэнэ Суварга" ХХК-тай хамтран хэмжилт судалгааны ажлыг гүйцэтгэж, "Чойжин ламын сүм музейн барилга"-ын хэсэгчилсэн засварын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулан ажиллалаа. Хэсэгчилсэн сэргээн засварлалтын ажлын нийт төсөвт өртөг 50,487,418 (Тавин сая дөрвөн зуун наян долоо мянга дөрвөн зуун арван найм) төгрөг болно. Хүрсэн түвшин: “Занхан сүм”-д хадгалагдаж буй үзмэр эд, өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулахаар сэргээн засварлах эрх бүхий "Зэндмэнэ Суварга" ХХК-тай хамтран хэмжилт судалгааны ажлыг гүйцэтгэж, "Чойжин ламын сүм музейн барилга"-ын хэсэгчилсэн засварын ажлын зураг төсөл, төсвийг	100%

						боловсрууллаа.	
						Хавсралт: 2 файл	
1.1.5	Музейн цогцолборын гадаад, дотоод орчин, сан хөмрөг, үзүүллэгийн танхимын “Гэрэлтүүлэг” төслийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлэх	Хандив 1,677,2	Төслийн тоо Төслийн гүйцэтгэлийн хувь	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 100	Музейн хадгалалт, хамгаалалт, орчин, орон зайг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор музейн цогцолбор орчны гадаа талбай, сүм доторх гэрэлтүүлгийн системийг шинэчлэх “Гэрэлтүүлэг” төслийг санаачлан, бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллалаа. Төслийн хүрээнд гэрэлтүүлгийн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Итали улсын “iGuzzini” брэндийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч “Аззурра” ХХК-тай хамтран музейн онцлогт тохирсон гэрэлтүүлгийн зураг, төсвийг нарийвчлан боловсруулж, Монголын Урлагийн Зөвлөлт төслийн менежмент, зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хариуцахаар хамтран ажиллаж байна. Төслийн нийт төсөв 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн зохицуулалтаар MCS Холдинг ХХК хандивлахаар шийдвэрлэж, талууд хоорондын “Гуравласан гэрээ” байгуулах эрх зүйн бэлтгэл ажил хангагдсан. Хүрсэн түвшин: Музейн цогцолбор орчны гадаа талбай, сүм доторх гэрэлтүүлгийн системийг шинэчлэх “Гэрэлтүүлэг” төслийг санаачлан, бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллалаа. MCS Холдинг, Монголын Урлагийн Зөвлөл, Музей хоорондын “Гуравласан гэрээ” байгуулах эрх зүйн бэлтгэл ажил хангагдсан. Хавсралт: 5 файл	100%
1.1.6	Музейн хөмрөгийн хадгалалт, сан	Хандив 16,0	Гэрээ, хамтын ажиллагааны хэрэгжилт	8	Эхний хагас жилд: 9	Музейн нийт сан хөмрөгийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, үзмэр, эд өлгийн зүйлийг биологийн нөлөөллөөс хамгаалах, хадгалалтын	100%

	хамгаалалтыг сайжруулах төслийг “Оркин монголиа ХХК”-тай хамтран хэрэгжүүлэх		Үзлэг, хяналтын тоо		Жилийн эцэст: 12	байдлын хэвийн орчныг бүрдүүлэх зорилгоор Олон улсын стандарт IPM /Integrated Pest Management/-ийн дагуу ахуйн шавж мэрэгчийн устгал, хяналтын үйлчилгээ эрхэлдэг “Оркин монголиа” ХХК-тай 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дугаар 26/06 “Ахуйн хортон шавж, мэрэгч устгал, хяналтын үйлчилгээний гэрээ” байгуулж, 16,000,000 (арван зургаан сая) төгрөгийн өртөг бүхий үйлчилгээг 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй гүйцэтгүүлэхээр хамтран ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө, албан тасалгаа зэрэг нийт 15 байрлалд 40 гаруй өгөөш занга байршуулж, ариутгал халдваргүйтгэл, хяналтын үзлэгийг 8 удаа хийж гүйцэтгэн нийт сан хөмрөг, үзмэр эд өлгийн зүйл, ажилтнуудын эрүүл мэндийг биологийн нөлөөллөөс хамгаалж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Хүрсэн түвшин: “Хортон шавжгүй сан хөмрөг” төслийг “Оркин монголиа” ХХК-тай хамтран хэрэгжүүлж, үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө, албан тасалгаа зэрэг нийт 15 байрлалд 40 гаруй өгөөш занга байршуулж, ариутгал халдваргүйтгэл, хяналтын үзлэгийг 8 удаа хийж гүйцэтгэсэн. Хавсралт: 9 файл	
1.2.	Соёлын нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 100,0 Байгууллагын төсөв 9,0 Хамтын	Үйл ажиллагааны тоо Зорилтын хэрэгжилтийн хувь	-	3 100	Соёлын нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулж, 4550 иргэнийг хамруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Хавсралт: 14 файл	100%

		ажилл агааны төсөв 8,5					
1.2.2	“Музейн нээлттэй өдрүүдийн хүрээнд “Өндөр гэгээн”-ий сүмийг онцлон сурталчилж, иргэд жуулчид, хүүхэд залуучуудын сэтгэл ханамжид нийцсэн үнэ төлбөргүй үйлчилгээг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх	Байгуу лагын төсөв 9,0	Үзэгчийн тоо	2300	Эхний хагас жилд: 4000 Жилийн эцэст: -	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоол, Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнийн баталсан “Музейн нээлттэй өдрүүд-2026” арга хэмжээний удирдамж, Соёлын өвийн хэлтсийн даргын 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дугаар 15/527 албан бичгийн дагуу “Музейн нээлттэй өдрүүд-2026” үйл ажиллагааг 2026 оны 3 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Энэ хүрээнд “Өндөр гэгээн Занабазар”-ын намтар, уран бүтээлийг онцлон сурталчлахын зэрэгцээ Их Монгол Улс байгуулагдсаны 820 жилийн ой, төр нийгмийн зүтгэлтэн Ерөнхий сайд асан А.Амар, Ж.Батмөнх, их зохиолч Д.Нацагдоржийн намтар, түүхэн үйл хэргийн талаарх мэдээллийг хүргэж, үндсэн үзүүлэгийн танхимаар тайлбарт үйлчилгээг 4619 хүнд үзүүлсэн байна. Хүрсэн түвшин: “Музейн нээлттэй өдрүүд-2026” үйл ажиллагааны хүрээнд “Өндөр гэгээн Занабазар”-ын намтар, уран бүтээлийг онцлон сурталчилж, үндсэн үзүүлэгийн танхимаар тайлбарт үйлчилгээг 4619 хүнд үзүүлсэн байна. Хавсралт: 16 файл	100%
1.2.3	“Өв соёлдоо хайртай хүүхдүүд” соёлын боловсролын хөтөлбөрийг санаачлан зохион байгуулж ЕБС-ийн	Хамтын ажилл агааны төсөв 8,5	Боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	-	Эхний хагас жилд: 550 Жилийн эцэст: -	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргад музейн захирлын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 20 “Хамтран ажиллах тухай” албан хүсэлтийг хүргүүлэн “Өв соёлдоо хайртай хүүхдүүд” соёлын боловсролын хөтөлбөрийг хамтран зохион байгуулсан. “Музейн нээлттэй өдөр”-ийн хүрээнд зохион	100%

	сурагчдыг оролцуулах					байгуулагдсан морин хуурын үзүүлбэр, үлгэрийн ертөнцөөр аялах сонирхолтой хөтөлбөрт Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн 583 хүүхэд оролцож, түүх, соёлын өвийн дурсгалт зүйлстэй танилцлаа. Хүрсэн түвшин: Нийслэлийн СБД-ийн ЗДТГ-ын дэмжлэгээр “Өв соёлдоо хайртай хүүхдүүд” соёлын боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж, 583 хүүхдийг хамруулав. Хавсралт: 11 файл	
Хоёр. Төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
2.1.	Музейн үйлчилгээ, маркетинг, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Байгууллагын төсөв 46,1	Хамтын ажиллагааны тоо Зорилтын хэрэгжилтийн хувь	-	3 100	Зорилтын хэрэгжилт хангагдсан.	100%
2.1.1	Олон улсын жишигт нийцсэн AI технологид суурилсан “E-GUIDE” музейн платформ нэвтрүүлж, иргэд жуулчдад хүргэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Байгууллагын төсөв 8,6	Платформын тоо Үйлчилгээ авсан нийт хүний тоо Гадаад үзэгчийн эзлэх хувь	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 5000 10	Музей үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд AI технологид суурилсан, 38 хэл дээр мэдээлэл хүргэх боломжтой “E-GUIDE” музейн тайлбарын системийг нэвтрүүлэхээр “Нова Хекс” ХХК-тай 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 01/-26401 “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж байна. Түүх, соёлын өвийн талаарх мэдээ, мэдээллийг хиймэл оюун ухаанд суурилсан цахим тайлбарлагч буюу “E-GUIDE” платформуор дамжуулан аудио, текст, зураг, дохионы хэлний орчуулгаар жуулчин бүрд хүртээмжтэй хүргэх, иргэд, жуулчид өөртөө үйлчлэх шинэ соёлыг бий болгохоор төлөвлөн ажиллаж, энэ хүрээнд QR кодоод суурилсан цахим тайлбар, олон хэлний орчуулга, аудио тайлбар бүхий платформ, контент удирдлагын админ систем, хэрэглээний тайлан, статистикийн мэдээлэл	100%

						зэрэг холбогдох мэдээллүүдийг бэлтгэлээ. Хүрсэн түвшин: Түүх, соёлын өвийн талаарх мэдээ, мэдээллийг хиймэл оюун ухаанд суурилсан цахим тайлбарлагч "E-GUIDE" платформоор дамжуулан аудио, текст, зураг, дохионы хэлний орчуулгаар жуулчин бүрд хүртээмжтэй хүргэх, музей үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн платформыг нэвтрүүлсэн. Хавсралт: 5 файл	
2.1.2	Байгууллагын хөгжлийн урт хугацааны маркетинг, брэндэнгийн төлөвлөгөөг боловсруулахад зөвлөх үйлчилгээ авч, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Байгууллагын төсөв 18,0	Мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээ Батлагдсан төлөвлөгөө	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	Байгууллагын хөгжлийн урт хугацааны маркетинг, брэндэнгийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд "Монгол Өмгөөлөгч" ХХК-аас зөвлөх үйлчилгээ авч, Захиргааны албаны дарга Б.Баярзул, Аж ахуйн албаны дарга Б.Сувд-Эрдэнэ, маркетингийн менежер Г.Сэлэнгэ нар хамтран байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагад тулгуурласан брэнд хөгжүүлэх бизнес төлөвлөгөөний судалгаа, шинжилгээг боловсруулж, батлуулсан. Музейн 2032 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний төсөл, зураглалыг хийж дээд шатны байгууллагын удирдлагуудад танилцуулсан. Хүрсэн түвшин: Байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагад тулгуурласан брэнд хөгжүүлэх бизнес төлөвлөгөөний судалгаа, шинжилгээг боловсруулж, батлуулсан. Музейн 2032 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний төсөл, зураглал хийгдсэн. Хавсралт: 4 файл	100%
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.	Үзэсгэлэн,	Байгуу	Төлөвлөсөн	-	5 100	Зорилтын хэрэгжилт хангагдсан	100%

	судалгааны бүтээл, хэлэлцүүлэг зохион байгуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	ллагын төсөв 100,2	ажлын тоо Зорилтын хэрэгжилтийн хувь				
3.1.5	Музейн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулж, иргэд жуулчдад хүртээмжтэй хэлбэрээр хүргэх ССАЖЗЯ-ны СТ 3.1.2	Байгууллагын төсөв 29,5	Шинээр нэмэгдсэн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Борлуулалтын орлого	-	Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 10,0	Музейн үзмэрээс сэдэвлэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл бүхий брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Бүтээгдэхүүний концепц, анхны загвар боловсруулах, үйлдвэрлэгч сонгох, үнийн санал авах ажлуудыг хийж, анхны бүтээгдэхүүн, дээжийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр олон нийтэд танилцуулж, борлуулалтыг эхлүүлэхээр төлөвлөн, ажиллаж байна. Хүрсэн түвшин: Музейн үзмэрээс сэдэвлэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүний анхны загвар, дээж бүтээгдэхүүнийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр танилцуулж, олон нийтэд танилцуулж, борлуулалтыг эхлүүлэхээр ажиллаж байна. Хавсралт: 2 файл	100%
3.2.	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын ажлыг зохион байгуулна.	Байгууллагын төсөв 6,0	Тоологдсон дурсгалт зүйлийн тоо	86	6377 100	Зорилгын хэрэгжилт хангагдсан	100%
3.2.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлыг гүйцэтгэж, соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн	Байгууллагын төсөв 10,0	Тоологдсон дурсгалт зүйлийн тоо Нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн	86 %	Эхний хагас жилд: 6377 100 Жилийн эцэст: -	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлын хүрээнд Салбар комиссоос холбогдох журмын дагуу тооллогын ажлыг музейн Өмч хамгаалах зөвлөлд 2026 оны 5 дугаар сарын 04-ний өдөр танилцуулж, тус зөвлөл хурлаар хэлэлцсэний дагуу музейн “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын	100%

	санд тайлагнах		хувь			тооллогын дэвтэр-2025” хэмээх 1-160 хуудасны дугаартай, нийт 160 хуудсанд 995 дэсийн 6378 ширхэг дурсгалт зүйл бичигдсэнээс 994 дэсийн 6377 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг тоолсон. Нэг үзмэрт 2 өөр хувийн дугаар өгч бүртгэсэн 1 дэсийн 1 ширхэг, дутсан, солигдсон, акталсан үзмэр, эд өлгийн зүйл байхгүй, мөн яаралтай сэргээн засварлах шаардлагатай 29 дэсийн 30 ширхэг, эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх саналтай 5 дэсийн 13 ширхэг, хасаж шилжүүлэх саналтай 20 дэсийн 20 ширхэг, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын ангилалд шилжүүлэх саналтай 12 дэсийн 14 ширхэг, хасаж, актлах саналтай 10 дэсийн 20 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг тайланд тусгаж, улсын комисст хүргүүлэхийг дэмжсэн санал, дүгнэлтийг 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдөр гарган ажилласан. Мөн улсын комиссоос чиглэл өгсний дагуу тооллогын ажлын тайланд дүгнэлт гаргуулахаар 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 61 дугаар албан бичгийг ССАЖЗЯ-ны Салбарын хяналт-Шинжилгээ, дотоод аудитын газарт хүргүүлж холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд заасан үүргийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Хүрсэн түвшин: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлыг гүйцэтгэж, соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 995 дэсийн 6378 ширхэг дурсгалт зүйл бичигдсэнээс 994 дэсийн 6377 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг тоолсон. Хавсралт: 8 файл	
3.3.	Музейн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, үзэгч,	Байгууллагын төсөв 70,0	Хөтөлбөр үйл ажиллагааны тоо Үзэгчдийн өсөлтийн хувь	2025 онд тасалба раар	9 10 3	Зорилтын хэрэгжилт хангагдсан.	100%

	үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлнэ.		Гадаад үзэгчийн эзлэх хувь	7530 үзэгч үйлчлүүлсэн.			
3.3.1	"Олон улсын музейн өдөр"-ийг тохиолдуулан "Хуваагдмал дэлхийг нэгтгэж буй музейнүүд" уриан дор "Бодь сэтгэлийн амар амгалан" өдөрлөг зохион байгуулах	Байгууллагын төсөв 15,0	Үйл ажиллагааны тоо Оролцогчдын тоо	15	Эхний хагас жилд: 16 300 Жилийн эцэст: -	Олон Улсын Музейн өдөр, Олон Улсын Гэр бүлийн өдөрт зориулж музейн соёлын боловсролын хөтөлбөрт суурилсан "ӨВ СОЁЛДОО ХАЙРТАЙ ГЭР БҮЛ" өдөрлөгийг 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж 300 гаруй иргэд, жуулчид, олон нийт, гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад үеийн төлөөллүүд өргөнөөр оролцсон. Өдөрлөгийн хүрээнд Музейн тайлбарт үйлчилгээтэй хамтатган Монгол Угсаатны Хэл Хуурчдын Холбооны өвлөн уламжлагчид ардын урлагийн тоглолт, түр үзэсгэлэнгээ толилуулж, Монгол Улсын Соёлын элч Б.Нарандэлгэр "Хөгт хүн" аялгуут бясалгалын хөтөлбөрийг удирдан зохион байгуулж, МУГБ Ш.Чимгээ "Сэтгэлийн боловсрол" гэр бүлд зориулсан лекц уншиж, аав ээжтэйгээ музейд зочлон ирсэн хүүхдүүд тэдэнд зориулсан боловсролын хөтөлбөрт хамрагдсанаараа уг хөтөлбөр үзэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн үйл ажиллагаа болсон. Хүрсэн түвшин: Олон Улсын Музейн өдөр, Олон Улсын Гэр бүлийн өдөрт зориулсан музейн соёлын боловсролын хөтөлбөрт суурилсан "ӨВ СОЁЛДОО ХАЙРТАЙ ГЭР БҮЛ" өдөрлөгийг зохион байгуулж 300 гаруй иргэд, жуулчид, олон нийт, гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад үеийн төлөөллүүд өргөнөөр оролцсон. Хавсралт: 12 файл	100%
3.3.2	Олон улсын "Хүүхдийн эрхийг	Байгууллагын	Үйл ажиллагааны	15	Эхний хагас	"ЧОЙЖИН ФЕСТИВАЛЬ" музейн зуны улирлын нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Олон улсын	100%

	хамгаалах өдөр"-т зориулан "Бүтээлч хүүхдүүд" уламжлалт өдөрлөг зохион байгуулах	төсөв 2,0	тоо Оролцогчдын тоо		жилд: 16 300 Жилийн эцэст: -	хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "БҮТЭЭЛЧ ХҮҮХДҮҮД" өдөрлөгийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулан ажилласан. Өдөрлөгт "Нийслэлийн засаг даргын дэргэдэх хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор", "Дон Боско Монгол", "Бадамлянхуа" хүүхдийн асрамж халамжийн төв, "Цөлийн сарнай сан" ТТБ -ын 300 хүүхэд, багш нарын хамт оролцож, Соёлын тэргүүний ажилтан дуучин Т.Амина, Улсын хүүхэд залуучуудын театрын залуу уран бүтээлчид болон хөтлөгч алиалагчдын бэлтгэсэн урлагийн тоглолтыг үзэхийн зэрэгцээ музейн тайлбарт үйлчилгээ, урлагийн боловсролын хөтөлбөр, "Хөгт хүн" уламжлалт хөгжимт бясалгалд хамрагдаж, өртөөчилсөн олон сонирхолтой тоглоом тоглон нэгэн өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлсэн. Өдөрлөгийн үеэр хүүхдүүдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон тайлбарт үйлчилгээг хүргэж, музейн тухай анхан шатны мэдэгдэхүүн олгох зорилгоор Авдар дахь музей, Цам, Мандала боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, оролцоог ханган ажилласан. Хүрсэн түвшин: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "ЧОЙЖИН КИДС ФЕСТИВАЛЬ"-ийн хүрээнд "БҮТЭЭЛЧ ХҮҮХДҮҮД" өдөрлөгийг уламжлал болгон зохион байгуулж, асрамж, халамжийн 4 төвийн 300 гаруй хүүхэд багачуудыг хамруулсан. Хавсралт: 12 файл	
3.3.4	"Музей ба бясалгал" уламжлалт өдөрлөгийн хүрээнд	Байгууллагын төсөв 3,0	Үйл ажиллагааны тоо Оролцогчдын	7	Эхний хагас жилд: 8 200	Музейн үйлчилгээг бүх насны иргэдэд хүртээмжтэй, нас сэтгэхүйн онцлогт тохируулан тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор Монголын иогчдын холбоотой хамтран	100%

	“Нарны мөргөл” зорилтот эвент зохион байгуулах		тоо		Жилийн эцэст: -	"Mongolia yoga festival 2026"-ийн хүрээнд “Өглөөний амгалан” өдөрлөгийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр мэргэжлийн багш нартай хамтран найм дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Нийслэлийн зургаан дүүргийн 200 гаруй иргэд оролцож, ногоон байгууламжид бясалгал, иогийн дасгал хөдөлгөөн хийж, музейн тайлбарт аялалд хамрагдан түүх, соёлын өвтэй танилцсан. Хүрсэн түвшин: Музей нь Монголын иогчдын холбоотой хамтран "Mongolia yoga festival 2026"-ийн хүрээнд “Өглөөний амар амгалан” өдөрлөгийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр мэргэжлийн багш нартай хамтран найм дахь жилдээ амжилттай зохион байгуулж, 200 гаруй иргэдийн хамруулсан. Хавсралт: 3 файл	
3.3.6	Хүүхэд, гэр бүлд зориулсан музейн боловсролын ажил зохион байгуулах	Байгууллагын төсөв 8,0	Боловсролын ажлын тоо Боловсролын ажилд хамрагдсан хүүхэд, гэр бүлийн тоо	-	Эхний хагас жилд: 5 500 Жилийн эцэст: 5 500	Музей нь хүүхэд, гэр бүлд Монгол улсын түүх, соёлын өвийг таниулан сурталчлах, мэдлэг мэдээлэл, урлагийн боловсрол дээшлүүлэх зорилгоор “Хайрцаг дахь музей”, “Цам”, “Мандала”, “Өв соёлдоо хайртай хүүхдүүд” зэрэг боловсролын хөтөлбөрийг нийслэл болон орон нутагт зохион байгуулж, нийт 1,508 хүүхэд багачууд, иргэдийг хамруулсан. Үүнд: - 2026 оны 3 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд “ӨВ СОЁЛДОО ХАЙРТАЙ ХҮҮХДҮҮД” соёлын боловсролын хөтөлбөрт 583 хүүхэд - 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр “Соёлын боловсрол-Нэг Монгол” нээлттэй өдөрлөгт оролцож, 300 гаруйн хүүхэд, иргэд - 2026 оны 5 дугаар сарын 16-ны өдөр “Өв соёлдоо хайртай гэр бүл” өдөрлөгт 100 гэр бүл, 200 том хүн, 125 хүүхэд, нийт 325 иргэн - 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр “Бүтээлч хүүхдүүд” үйл ажиллагааны	100%

						оролцогч 300 хүүхдүүд Хүрсэн түвшин: Музей нь хүүхэд, гэр бүлд Монгол улсын түүх, соёлын өвийг таниулан сурталчлах, мэдлэг мэдээлэл, урлагийн боловсрол дээшлүүлэх зорилгоор “Хайрцаг дахь музей”, “Цам”, “Мандала”, “Өв соёлдоо хайртай хүүхдүүд” зэрэг боловсролын хөтөлбөрийг нийслэл болон орон нутагт зохион байгуулж, нийт 1,508 хүүхэд багачууд, иргэдийг хамруулсан. Хавсралт: 8 файл	
3.3.8	“Цомцог гэрүүд”-ийг “Арт шоп”, “Жуулчны мэдээллийн төв” хэлбэрээр ажиллуулж иргэд, гадаад, дотоодын жуулчдад мэдээлэл түгээх, музейн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах	Байгууллагын орлого 7,1	Хувийн хэвшилтэй байгуулсан гэрээ Төвөөр үйлчлүүлсэн жуулчдын тоо	1 5000	Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 8000	Тогтвортой аялал жуулчлал” болон “Соёлын аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Бэлэг дурсгалын дэлгүүр”, “Жуулчны мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор “Монголиан Гайд Тур” ХХК-тай 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дугаар Х/Г-04 “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны үр дүнд жуулчдад Чойжин ламын сүм музейн талаар мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэх, үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын урсгалыг татах, соёлын өвийн үнэ цэнийг нэмэгдүүлэхээр музейн үйл ажиллагаа, түүх, соёлын өвийг олон нийтэд таниулан сурталчлан ажиллаж байна. Мэдээллийн төв нь хагас жилийн байдлаар 843 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн. Хүрсэн түвшин: “Монголиан Гайд Тур” ХХК-тай 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дугаар Х/Г-04 “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж, хагас жилийн байдлаар 843 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн. Хавсралт: 9 файл	100%
3.3.9	Үзэгч,	Улсын	Судалгаанд	-	Эхний	Музейн үзэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ	100%

	үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах	төсөв	хамрагдсан хүний тоо		хагас жилд: 100 Жилийн эцэст: 500	шаардлагыг тодорхойлох, тэдний сэтгэл ханамжид суурилсан менежментийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд хоёр төрлийн түүвэр судалгааг боловсруулан, амжилттай зохион байгууллаа. Судалгааг зорилтот бүлэгт илүү хүртээмжтэй болгох үүднээс цаасан болон цахим (хосолсон) хэлбэрээр явуулсан бөгөөд 100 гаруй оролцогчоос нийт 160 нэгж судалгааны өгөгдөл, мэдээллийг цуглуулсан ба цугларсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг музейн дунд, урт хугацааны маркетингийн бодлого, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт хүргэхэд суурь үзүүлэлт болгон ашиглахаар төлөвлөн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Музейн үзэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, тэдний сэтгэл ханамжид суурилсан менежментийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд хоёр төрлийн түүвэр судалгааг боловсруулж, 100 гаруй оролцогчоос нийт 160 нэгж судалгааны өгөгдөл, мэдээллийг цуглуулсан. Хавсралт: 2 файл	
3.4.	Зорилтот сургалтуудыг зохион байгуулж хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлнэ.	Байгууллагын төсөв 10,0	Сургалтын тоо оролцогчийн тоо	-	2 50	Зорилтын хэрэгжилт хангагдсан.	100%
3.4.1	Монгол-Англи болон бусад хэлээр тайлбарлах “Хөтөч тайлбарлагч”-ийг бэлтгэх зорилтот сургалт зохион	Байгууллагын төсөв 8,0	Сургалтын тоо Бэлтгэгдсэн хөтөч тайлбарлагчдын тоо	-	Эхний хагас жилд: 1 20 Жилийн	Монголиан гиад тур ХХК-тай хамтран гадаад, дотоодын жуулчдад музейн түүх, соёлын өв бүхий үзмэрийг тайлбарлан таниулах хөтөч тайлбарлагч нарт судалгаа шинжилгээний үндэслэлтэй мэдээлэл хүргэж, чадавхжуулах зорилгоор "Чойжин ламын сүм музейг	100%

	байгуулах ССАЖЗЯ-ны 4.2.3, ГТ 4.2.3	СТ			эцэст: -	тайлбарлах эрх олгох" онол, практик хосолсон сургалтыг 2026 оны 4 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 14 хөтөч тайлбарлагчийг хамруулж, "Музейн салбар, олон улсын музейн чиг хандлага, "Өндөр гэгээн Занабазарын намтар, уран бүтээл", "Лувсанхайдав хутагт ба Чойжин ламын сүмд холбогдох архивын баримтуудаас", "Цам, цамын дүрүүд, утга бэлгэдэл", "Урлахуй ухааны төрөл, Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй бүтээлүүд", "Чойжин ламын сүм музейн дурсгалт уран барилга, дүрс чимэглэлийн утга бэлгэдэл" зэрэг онолын хичээл, Чойжин ламын сүм музейн дурсгалт уран барилга, үзүүлэлийн танхим болох сүмүүд, түүнд хадгалагдан буй соёлын өвийг тайлбарлах дадлага хичээлийг хүргэж, мэдлэг ур чадварыг дээшлүүлээ. Сургалтад хамрагдсан хөтөч тайлбарлагч нарт гэрчилгээ, музейг тайлбарлах эрхийн үнэмлэхийг олгож, жуулчдын хамт ирэхдээ музейд үнэ төлбөргүй нэвтэрч тайлбар хийх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Хүрсэн түвшин: Чойжин ламын сүм музей нь Монголиан гиад тур ХХК-тай хамтран Монгол орныг зорин ирэх жуулчдад түүх, соёлын өвөө тайлбарлан таниулах хөтөч тайлбарлагч нарт судалгаа шинжилгээний үндэслэлтэй мэдээлэл хүргэж, чадавхжуулах зорилгоор "Чойжин ламын сүм музейг тайлбарлах эрх олгох" онол, практик хосолсон сургалтыг 2026 оны 4 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулж, 14 хөтөч тайлбарлагчийг хамрууллаа. Сургалтад хамрагдсан хөтөч тайлбарлагч нарт гэрчилгээ эрхийн үнэмлэх олголоо. Хавсралт: 7 файл	
--	---	----	--	--	----------	--	--

3.4.2	Байгууллагад цагийн болон сайн дурын ажил хийх оюутан залуучуудад зориулсан сургалт зохион байгуулах	Байгууллагын төсөв 2,0	Сургалтын тоо Оюутан, залуучуудын хамрагдалт	-	Эхний хагас жилд: 1 30 Жилийн эцэст: -	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуультай байгуулсан хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд соёлын өвийг олон нийтэд таниулах, музейн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх, залуу үеийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Чойжин ламын сүм музейд сайн дурын ажилтан, цагийн ажилтан бэлтгэх" 4 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийгмийн ажлын, аялал жуулчлалын мэргэжлээр суралцаж буй 30 оюутан сонгогдон хамрагдаж, сургалтын хугацаанд музейн үйл ажиллагаа, үзмэр тайлбарлах ур чадвар, зочин хүлээн авах үйлчилгээний соёл, соёлын өвийн боловсролын талаарх мэдээлэл, мэдлэг авч, практик орчинд ажилласан. Хүрсэн түвшин: Чойжин ламын сүм музей Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд соёлын өвийг олон нийтэд таниулах, музейн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх, залуу үеийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Чойжин ламын сүм музейд сайн дурын ажилтан, цагийн ажилтан бэлтгэх" 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, 30 оюутныг сонгон хамрууллаа. Хавсралт: 7 файл	100%
3.5.	Хүний нөөцийн чадавх, бодлого, эрх зүйн үр нөлөөг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангана.	Байгууллагын төсөв 39	Батлагдсан хөтөлбөрийн тоо Зорилтын хэрэгжилтийн хувь	-	2 100	Зорилтын хэрэгжилт хангагдсан.	100%
3.5.1	Албан хаагчдын нийгмийн	Байгууллагын	Батлагдсан хөтөлбөрийн	-	Эхний хагас	Музейн ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2026 оны	100%

	баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	төсөв 19,5	хэрэгжилтийн хувь Хүний нөөцийн тогтвортой байдлын хувь		жилд: 100 Жилийн эцэст: 60 төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Музейн ажилтнууд өвлийн улиралд төвийн дулаан төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүйн улмаас, халаалтгүй хүнд нөхцөлд ажиллаж байгааг дээд шатны удирдах байгууллагад танилцуулснаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, удирдлагууд музейн орчин нөхцөлд ирж ажиллан, Сайдын 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Зардал төсөв батлах тухай” тушаалаар ажилтнуудын ажлын байрыг дулаан оффист шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. - Музейн захирлын 2026 оны 5 дугаар саны 01-ний өдрийн дугаар Б/14 “Ажилтнуудад нэг удаагийн тэтгэмж олгох тухай” тушаалаар үзвэрийн танхимын үйлчилгээний ажилтан Ж.Баасантогод 6,500,000 төгрөг, үзмэр харгалзагч М.Мөнхтуулд 1,000,000 төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон. - Музейн захирлын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар Б/05 “Нэгдүгээр улиралд олгох ур чадварын нэмэгдлийн хувь батлах тухай”, 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн дугаар Б/13 “Хоёрдугаар улиралд олгох ур чадварын нэмэгдлийн хувь батлах тухай” тушаалаар ажилтнуудад нэмэгдэл хөлсийг олгосон. - Музейн захирлын 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар Б/03 “Хоол, унааны зардлыг нэмэх тухай” тушаалаар ажилтнуудад олгох хоол, унааны зардлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн А/64 тоот захирамжид нийцүүлэн нэмэгдүүлэхээр ССАЖЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Хүрсэн түвшин: Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар
--	---	---------------	---	--	--

						хавсралтаар батлагдсан "Музейн ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2026 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн хэрэгжилт бүрэн хангагдсан. Хавсралт: 5 файл	
3.5.2	Албан хаагчдын сургалтын хэрэгцээнд суурилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Байгууллагын төсөв 19,5	Батлагдсан төлөвлөгөө Сургалтын тоо	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 8	Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр хавсралтаар "Чойжин ламын сүм музейн ажилтнуудын 2026 оны сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулсны дагуу, ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШУТИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуультай хамтран музейн ажилтнуудыг чадавхжуулах "Үйлчилгээ ба хөгжил дэвшил" сургалтын хөтөлбөр боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр дараах сургалтуудыг зохион байгуулж, нийт ажилтнуудыг хамруулсан. Үүнд: - "Дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлага" сэдвээр ШУТИС, НХС-ийн Нийгмийн ажил хөтөлбөрийн ахлах багш Б.Болормаа доктор (Ph.D), дэд профессор - "Жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ" сэдвээр ШУТИС, НХС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч Н.Нямдорж доктор (Ph.D) - "Үйлчилгээний ёс зүй ба харилцаа" ШУТИС, НХС-ийн Нийгмийн ажил хөтөлбөр хариуцсан дэд профессор Ч.Должинсүрэн доктор (Ph.D), дэд профессор Ажилтнуудыг мэргэжлийн зэрэг болон сертификат олгох мэргэшүүлэх дараах сургалтад хамруулсан. Үүнд: - "Музейн захирлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлах тухай" А/21 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, тус дэд хорооны даргаар сонгогдсон Х.Болор-Эрдэнэ	100%

						Удирдлагын академийн “Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах нь” сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. - Хүсэлт гаргасан ажилтнуудыг Англи хэлний түвшин ахиулахаар үзмэр харгалзагч М.Мөнгөнтуулийг анхан шатны сургалтад хамруулж байна. - “Ёс зүйтэй байгууллагын соёл” сэдэвт сургалтыг байгууллагын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж, нийт ажилтнууд хамрагдсан. Хүрсэн түвшин: Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр хавсралтаар “Чойжин ламын сүм музейн ажилтнуудын 2025 оны сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулсны дагуу, хэрэгжилтийг хангах зорилгоор Байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах сургалтын хөтөлбөр эхний хагас жилийн байдлаар бүрэн хангагдсан. Хавсралт: 9 файл	
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
4.1.	Байгууллагын үйл ажиллагаанд нийтлэг мөрдөгдөх хуулийн хэрэгжилтийг хангана.	Байгууллагын төсөв 41,0	Хуулийн хэрэгжилтийн хувь	-	100	Зорилтын хэрэгжилт хангагдсан.	100%
4.1.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	Байгууллагын төсөв	Тайлангийн тоо	-	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	Музейн батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомж, зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажиллаж байна. Санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь чанартай боловсруулж, дээд шатны байгууллагад тогтмол тайлагнаж байна. Хүрсэн түвшин: Музейн батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомж, зориулалтын дагуу үр	100%

						ашигтай захиран зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажиллаж байна. Санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь чанартай боловсруулж, дээд шатны байгууллагад тогтмол тайлагнаж байна.	
4.1.2	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, санхүүгийн тайланд аудит хийлгэх	Байгууллагын төсөв 5,0	Аудитын дүгнэлтийн үр дүн	-	Эхний хагас жилд: Зөрчилгүй Жилийн эцэст: Зөрчилгүй	Музей нь 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын “Өөрчлөлтгүй дүгнэлт” авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу “Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан Үндэсний аюудитын газарт хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Акт, төлбөргүй болно. Сар бүрийн мэдээ тайланг хуулийн хугацаанд гарган холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Музей нь 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын “Өөрчлөлтгүй дүгнэлт” авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу “Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан Үндэсний аюудитын газарт хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Акт, төлбөргүй болно. Сар бүрийн мэдээ тайланг хуулийн хугацаанд гарган холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт: 2 файл	100%
4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны орлого, үзэгчийн тоог нэмэгдүүлж ажиллах	Улсын төсөв	Орлого, үзэгчийн өсөлтийн хувь	2025 онд 200,0	Эхний хагас жилд: 20 Жилийн эцэст: 50	Чойжин ламын сүм музейн 2026 оны төсвийн жилд бий болсон орлого нь 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 140,496,760 (нэг зуун дөчин сая дөрвөн зуун ерэн зургаан мянга долоон зуун жар) төгрөг болно. Орлогын төлөвлөгөөг суурь түвшинтэй харицуулахад 30	100%

						хувиар нэмэгдсэн байна. Хүрсэн түвшин: Чойжин ламын сүм музейн 2026 оны төсвийн жилд бий болсон орлого нь 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 140,496,760 (нэг зуун дөчин сая дөрвөн зуун ерэн зургаан мянга долоон зуун жар) төгрөг болно. Орлогын төлөвлөгөөг суурь түвшинтэй харицуулахад 30 хувиар нэмэгдсэн байна.	
4.1.4	Музейн үзэгч, иргэд жуулчдад зориулсан авто зогсоолын үйл ажиллагааны менежментийг сайжруулахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран гурван талт гэрээ байгуулж, зөвшилцөж ажиллах	Улсын төсөв	Гурван талт гэрээ Гэрээ, хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь	1	Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 100	Байгууллагын эзэмшлийн талбайд байрлах авто зогсоолыг түрээсээр ашиглуулах нээлттэй сонгон шалгаруулалтыг зохих журамд нийцүүлэн зохион байгуулж, 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байгууллага хоорондын хамтарсан гурван талт гэрээг байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, үр дүнтэй ажилласан. Гурван талт гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж, түрээслүүлэгч болон түрээслэгч нар гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Түрээслэгч байгууллага Голден билэгт ХХК, Түрээслүүлэгч байгууллага Чойжин ламын сүм музейн хооронд байгуулсан 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн ЧЛСМ/2025/01 тоот гэрээний хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар сунган ажилласан. Хүрсэн түвшин: Байгууллагын эзэмшлийн талбайд байрлах авто зогсоолын ЧЛСМ/2025/01 тоот "Түрээсийн гэрээ"-ний хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар сунган ажилласан. Хавсралт: 1 файл	100%

4.1.5	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй эцэслэн шийдвэрлэж, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулж ажиллах	Байгууллагын төсөв	Өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн хувь	-	Эхний хагас жилд: 100 Жилийн эцэст: 100	Иргэд албан байгууллага, ажилтнуудаас ирсэн өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яамны Төрийн захиргаа удирдлагын газарт улирал бүр мэдээг албан бичгээр хүргүүлэн ажилласан. Хагас жилийн байдлаар ажилтнуудаас чөлөө хүссэн 9, бусад 2, нийт 11 өргөдөл ирсэн ба хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажилласан. Музейд ялгаварлан гадуурхалт, эрхийг хязгаарласан зэрэг бусад асуудлаар гарсан өргөдөл, гомдол ирээгүй болно. Хүрсэн түвшин: Иргэд албан байгууллага, ажилтнуудаас ирсэн өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яамны Төрийн захиргаа удирдлагын газарт улирал бүр мэдээг албан бичгээр хүргүүлэн ажилласан. Хагас жилийн байдлаар ажилтнуудаас чөлөө хүссэн 9, бусад 2, нийт 11 өргөдөл ирсэн ба хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажилласан. Хавсралт: 2 файл	100%
4.1.8	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв 10,0	2026 оны хэрэгжилтийн хувь	-	Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 70	Музей нь нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зоригор байгууллагынхаа “Нээлттэй мэдээлэл”-ийг музейн веб хуудас, Фэйсбүүк хуудас, шилэн дансаар дамжуулан олон нийтэд нээлттэй байршуулан ажилласан. Мөн Shilen.gov.mn нээлттэй мэдээллийн нэгдсэн системд 2024 оны 2 дугаар улирлаас эхлэн хэрэгжилтийг тайлагнасан. Бид Нова Хекс ХХК-тай 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 01-26401 “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор музейн цахим хуудсыг шинэчлэн сайжруулахаар ажиллаж	100%

						байна. Хүрсэн түвшин: Музей нь нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зоригор байгууллагынхаа “Нээлттэй мэдээлэл”-ийг музейн веб хуудас, Фэйсбүүк хуудас, шилэн дансаар дамжуулан олон нийтэд нээлттэй байршуулан ажилласан.	
4.1.10	Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зорилгоор музейн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулах	Байгууллагын төсөв 18,0	Цэцэрлэгжүүлэлтийн талбай (м²) Ногоон байгууламжийн тогтмол арчилгааны давтамж	-	Эхний хагас жилд: 6200 (м²) 2 Жилийн эцэст: 1	Чойжин ламын сүм музейн 6,381 м² таримал зүлгийн насжилтыг уртасгах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах цогц арчилгааны ажлыг хаврын улиралд технологийн дагуу гүйцэтгэлээ. Ажлын хүрээнд зориулалтын техникээр хөрсийг 7–10 см гүн нүхэлж сийрүүлэн, кальци, магни, фосфор бүхий олон үйлдэлт бордоогоор ургалтыг дэмжив. Мөн сийрэгжсэн хэсгүүдийг олон наст зүлгийн үрээр нөхөн сэргээж, чийг барилтыг сайжруулах 0.5–1 см зузаан элсэн хучилт хийлээ. Үүний зэрэгцээ музейн хашаан дахь 100 гаруй монос, шар хуайс, тавилгана зэрэг гоёл чимэглэлийн мод, сөөгийн хэлбэржүүлэлт, засалт, сийрүүлэлт, усалгаа болон хортон шавжийн эсрэг арчилгааг иж бүрэн гүйцэтгэв. Энэхүү цогц арчилгааны үр дүнд ногоон байгууламжийн насжилт уртсаж, экологийн ач холбогдол нь 30 гаруй хувиар өссөнөөс гадна музейг зорин ирэх үзэгч, үйлчлүүлэгчдийн ая тухтай, таатай орчин бүрдлээ. Хүрсэн түвшин: Ногоон байгууламжийн насжилт уртсаж, хүлэмжийн хий болон тоосжилтыг шүүх экологийн үр ашиг 30 гаруй хувиар өссөнөөр музейн орчинд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, үзэгч, үйлчлүүлэгчдийн ая тухтай амрах таатай баянбүрд бүрдсэн түвшинд хүрэв.	100%

						Хавсралт: 9 файл	
4.1.11	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэж, музейн ажилтнуудыг сургалтад хамруулах	Байгууллагын төсөв 1,0	Тодотгол хийгдсэн Сургалтад хамрагдсан ажилтны тоо	1	Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: 18	Монгол Улсын Шадар сайдын 2017 оны “Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэн батлах тухай” дугаар 75 тушаал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу музейн бүтэц орон тоонд гарсан өөрчлөлтөй холбогдуулан музей захирлын 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дугаар А/53 “Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги томилох тухай” тушаалаар “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн”, “Гал унтраах бүрэлдэхүүн”, “Аврах бүрэлдэхүүн”, “Хэв журам сахиулах бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн байгуулсан. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэж, музейн ажилтнуудад болзошгүй эрсдэлийн үед яаралтай авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг олгон ажилласан. Хүрсэн түвшин: Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэж, музейн ажилтнуудад болзошгүй эрсдэлийн үед яаралтай авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг олгон ажилласан. Хавсралт: 4 файл	100%
4.1.12	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг батлуулж, бодлогын хэрэгжилтийн ханган ажиллах	Байгууллагын төсөв 2,8	Батлагдсан төлөвлөгөө Үйл ажиллагаа Ёс зүйн зөрчил шийдвэрлэлт	1	Эхний хагас жилд: 1 2 100 Жилийн эцэст: 4 100	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу музейн захирлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дугаар А/21 “Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлах тухай” тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Чойжин ламын сүм музейн дэргэдэх ёс зүйн дэд хорооны 2026 оны ажлын төлөвлөгөөг батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Удирдлагын академиас 2026 оны 4 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд	100%

						зохион байгуулсан байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтад Ёс зүйн дэд хорооны дарга Х.Болор-Эрдэнэ хамрагдаж, гэрчилгээ гардан авсан. - Байгууллагын ёс зүйн хамтын үнэт зүйлсийг тодорхойлох, ажилтнуудын ажлын байран дахь харилцаа, хандлага болон зөв зан төлөвийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгууллагын эрхэм зорилгыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэх, хүндэтгэлтэй, хариуцлагатай харилцаа, байгууллагын соёлыг дээшлүүлэх зорилгоор “Ёс зүйтэй байгууллагын соёл” Хүрсэн түвшин: Музейн захирлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дугаар А/21 “Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлах тухай” тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Чойжин ламын сүм музейн дэргэдэх ёс зүйн дэд хорооны 2026 оны ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хавсралт: 3 файл	
--	--	--	--	--	--	--	--

Тайлагнасан:

Захирагч
(албан тушаал)



Д. Монхчулуун